



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/101

Хэрлэн сум

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50.3, 50.4, 50.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (Галшар, Цэнхэрмандал, Баян-Овоо сум) зураг төсөл, “Стандарт хэмжилзүйн газрын тоног төхөөрөмж” авах ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны  
дарга:

Т.Батдорж

Худалдан авах ажиллагааны  
газрын ахлах мэргэжилтэн

Нарийн бичиг:

Б.Должинсүрэн

Худалдан авах ажиллагааны  
газрын мэргэжилтэн

Гишүүд:

М.Хишигбаяр

Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын барилга  
хот байгуулалтын хэлтсийн  
дарга

Э.Одхүү

Иргэний төлөөлөл


Д.Оюун

Төрийн бус байгууллагын  
Төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Т.Батдорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ



231010406

